



**“ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН
ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Бага тойруу, ШУТИС-ийн төв номын сангийн 605 тоот
Утас: 31-55-63, Факс: (976-11)31-55-63

Вэб хаяг: www.m-jeed.edu.mn

2015. 10.26 № 135

танай _____ -ны № _____ -т

Г МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН,
ЗАХИРАЛ Р.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Г Магистр, докторын сургалтын тухай 1

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд Япон Улсын их, дээд сургуулиудад 2015 оны 10 сарын байдлаар тус сургуулиас 5 багш, судлаачид /*магистр 2, доктор 3*/ зэргийн сургалтад хамрагдаад байна. Зэргийн сургалтад хамрагдаж буй багш, судлаачдын сурлагын дүн, мэдээ, тайланг холбогдох судалгааны баг, сургуулийн ажлын хэсгийн хэмжээнд хагас жил тутам авч хэлэлцэн, үр дүнг тооцож ажиллахыг хүсье.

Төслийн санхүүжилтээр 2016 оны 04 дүгээр сараас эхлэн магистр, докторын сургалтын хөтөлбөрт элсэн суралцах багш, судлаачдын урьдчилсан бүртгэлийг сургуулийн ажлын хэсэг дээрээ хийж, тавигдах шаардлагыг хангаж буй багш, оюутны нэрс болон холбогдох мэдээллийг 2015 оны 12 дугаар сарын 01-ны дотор Төсөл хэрэгжүүлэх нэгжид ирүүлнэ үү.

Магистрын сургалтын хөтөлбөр:

Суралцах хугацаа: Япон Улсад - 2 жил хүртэл

Хамрах хүрээ:

- а/ Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр МУИС болон ШУТИС-д ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан болон магистрын зэрэггүй багш нар;
- б/ МУИС болон ШУТИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтаран ажиллаж буй багш, судлаачид болон эрдэм шинжилгээний ажилтан;

Тавигдах шаардлага:

- а/ Монгол Улсын иргэн байх, 35 нас хүртэл;
- б/ Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж төгссөн байх;
- в/ Гадаад хэлний шалгалт: Япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 түвшин, эсвэл Англи хэлний TOEFL шалгалтын оноо PBT-500, IELTS шалгалтын оноо 5.0 ба түүнээс дээш байх;

- г/ Японы их сургуульд элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх;
- д/ Сургууль /ажлын газар/ нь магистрын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;
- е/ Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцлийг зөвшөөрсөн байх;

Докторын сургалтын хөтөлбөр:

Суралцах хугацаа: Япон Улсад - 3 жил хүртэл

Хамрах хүрээ:

- а/ Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр МУИС болон ШУТИС-д ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан, докторын зэрэггүй багш нар;
- б/ МУИС болон ШУТИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж буй багш, судлаачид, болон эрдэм шинжилгээний ажилтан;

Тавигдах шаардлага:

- а/ Монгол Улсын иргэн байх, 40 нас хүртэл;
- б/ МУИС болон ШУТИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр ажиллаж буй багш, ажилтан
- в/ Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж төгссөн байх;
- г/ Гадаад хэлний шалгалт: Япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 түвшин, эсвэл Англи хэлний TOEFL шалгалтын оноо PBT-500, IELTS шалгалтын оноо 5.0 ба түүнээс дээш байх;
- д/ Японы их, дээд сургуулиудад элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх;
- е/ Сургууль /ажлын газар/ нь докторын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;
- ё/ Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцлийг зөвшөөрсөн байх;

Дээрх шаардлагыг хангасан нэр дэвшигчдийн бүрдүүлэх материалын жагсаалт

- а/ Анкет; /маягтын дагуу/
- б/ Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- в/ Бакалавр /магистр/-ын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- г/ Япон, эсвэл Англи хэлний түвшин тогтоох шалгалт өгсөн батламжийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /Сүүлийн 2 жилд өгсөн байх/;
- д/ Япон талын их, дээд сургуулиас ирүүлсэн суралцах эрхийн бичиг;
- е/ Сургуулийн /ажлын газрын/ тодорхойлолт;
- ё/ Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт;
- ж/ Судалгааны ажлыг удирдаж буй хоёр талын их сургуулийн профессорын тодорхойлолт;

- й/ Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ, уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцлийг зөвшөөрсний үндсэн дээр элсэхийг хүссэн өргөдөл /Маягт харгалзахгүй/;
- к/ 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зураг /Сүүлийн 3 сард авахуулсан байх/;
- л/ Бүртгэлийн хураамж;

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



Д.НАМСРАЙ